



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 4/48

Мандалговь

“Ерөнхий боловсролын сургуулиудын
хэрэгцээнд автомашин / Дэрэн сумын ЕБС,
ГИЦС, Цэгц билэг, Мандал, Хүмүүнлэг” нийлүүлэгчийг
сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Ерөнхий боловсролын сургуулиудын хэрэгцээнд автомашин / Дэрэн сумын ЕБС, ГИЦС, Цэгц билэг, Мандал, Хүмүүнлэг” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: А.Нарантуяа (Аймгийн Засаг Даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Т.Төрбат (Иргэний төлөөлөл)

Х.Анхбаяр (Хот тохижуулах газрын дарга)

Л.Мөнхзул (Боловсрол соёл урлагийн газрын

мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын ХАА

хариуцсан мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (А.Нарантуяа)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060193